



СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Их-Уул дулаан ХХК-ийн 2023 оны  
жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/21/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын  
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн  
Захирал: Ч.Энхчимэг  
Утас: 77233030 Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Аудитор: М.Мөнхтөгс  
Утас: 77233030 Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/259  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИХ-УУЛ  
ДУЛААН ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
П.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Их-Уул дулаан ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул дулаан ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд 55,5 сая төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, дулааны шугам шинэчилж, ус түгээх худгийг автоматжуулсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитаар нийт 36.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, ААНОАТ, НӨАТ-ын тайлагналтай холбоотой 32.7 сая төгрөгийн алдааг залруулах шаардлагатай ба цахим и-баримтгүй 3.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

#### Бусад асуудлын хэсэг

Их-Уул дулаан ХХК нь ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 11 дугаар тогтоолоор нийт орлогыг 549.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 687.8 сая төгрөгөөр байхаар нэмэлт тодотгол хийснээс 96 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040537

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



**ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлэлт	2022.12.31	2023.12.31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,648,896.15	20,971,596.63
1.1.2	Дансны авлага	31,381,044.72	41,539,545.98
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	3,001,672.23	5,170,505.77
1.1.6	Бараа материал	55,131,304.42	58,060,292.19
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	91,162,917.52	125,741,940.58
1.2.1	Үндсэн хөрөнгө	411,637,510.28	397,268,549.38
1.2.2	Биет бус хөрөнгө	27,450,400.00	27,450,400.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	24,378,082.94	21,896,403.47
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	463,465,993.22	446,615,352.85
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>554,628,910.75</b>	<b>572,357,293.43</b>
2.1.1.1	Дансны өглөг	1,122,159.78	893,883.68
2.1.1.3	Татварын өр	1,316,265.63	5,256,208.37
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,438,425.41	6,150,092.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,438,425.41	6,150,092.05
2.3.1	Өмч: - төрийн	452,314,117.00	452,314,117.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	81,142,118.33	81,142,118.33
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	120,890,381.54	154,327,881.54
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(102,156,131.53)	(121,576,915.49)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	552,190,485.34	566,207,201.38
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	554,628,910.75	572,357,293.43

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	476,493,238.55	528,716,008.37
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	443,758,984.37	473,530,898.10
3	Нийт ашиг (алдагдал)	32,734,254.18	55,185,110.27
10	Ерөнхий ба удирдлагын зардал	68,600,788.92	71,996,324.76
11	Санхүүгийн зардал	120,300.00	127,890.00
12	Бусад зардал	136,400.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(36,123,234.75)	(16,939,104.49)
19	орлогын албан татвар	24,378,082.94	2,481,679.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(11,745,151.81)	(19,420,783.96)
22	Тайлант үеийн ашиг	(11,745,151.81)	(19,420,783.96)
24	Орлогын нийт дүн	(11,745,151.81)	(19,420,783.96)

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	452,314,117.00	8,235,402.00	-	(11,745,149.81)	448,804,369.19
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	72,906,716.33	120,890,381.54	(90,410,981.72)	103,386,116.15
<b>2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	452,314,117.00	81,142,118.33	120,890,381.54	(102,156,131.53)	552,190,485.34
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(19,420,783.96)	(19,420,783.96)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	33,437,500.00	-	33,437,500.00
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	452,314,117.00	81,142,118.33	154,327,881.54	(121,576,915.49)	566,207,201.38

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	522,662,149.97	571,480,583.99
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	522,662,149.97	565,632,897.79
	Буцаан авсан албан татвар	0.00	60,510.00
	Бусад мөнгөн орлого	0.00	5,787,176.20
1.2	Мөнгөн зарлага (-)	517,559,874.70	541,120,483.51
	Ажиллагчдад төлсөн	160,925,419.00	188,178,130.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	46,770,349.66	51,936,126.94
	Бараа материал худалдан авахад төлсөн	145,334,838.00	59,700,300.00
	Ашиглалтын зардалд төлсөн	37,301,703.90	55,549,684.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	86,072,537.00	130,367,547.00
	Татварын байгууллагад төлсөн	35,157,076.14	44,990,801.57
	Даатгалын төлбөрт төлсөн	348,300.00	316,650.00
	Бусад мөнгөн зарлага	5,649,651.00	10,081,244.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,102,275.27	30,360,100.48
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	48,000,000.00	11,037,400.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	48,000,000.00	11,037,400.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(48,000,000.00)	(11,037,400.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(42,897,724.73)	19,322,700.48
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,546,618.88	1,648,896.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,648,894.15	20,971,596.63

## 2.5 ТУЗ-аар батлагдсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2023 оны төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
		IV=I+II+III	V	VI=V-IV	VII=V/IV
1	Халаалтын орлого	519,159,028	494,462,322.0	(24,696,706)	95%
2	Цэвэр усны орлого	9,896,836	13,442,000.0	3,545,164	136%
3	Бохир усны орлого	2,211,686	2,211,686	-	100%
4	Бусад орлого	18,600,000	18,600,000	-	100%
<b>Орлогын дүн</b>		<b>549,867,550</b>	<b>528,716,008</b>	<b>(21,151,542)</b>	<b>96%</b>
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	328,322,994	242,345,910	(85,977,084)	74%
2	НДШимтгэлийн зардал	44,593,601	31,067,248.00	(13,526,353)	70%
3	Нүүрс	105,450,000	66,148,460.0	(39,301,540)	63%
4	Шатахуун	73,538,000	52,991,963.2	(20,546,037)	72%
5	Гэрэл цахилгаан	44,750,685	44,750,684.5	-	100%
6	Бичиг хэрэг	846,500	846,500.0	-	100%
7	Цахилгаан холбоо	640,800	640,800.0	-	100%
8	Албан томилолт	620,000	748,000.0	128,000	121%
9	Хангамжийн материал	19,197,000	19,197,000.0	-	100%
10	Сэлбэг хэрэгсэл тоног төхөөрөмж	17,363,818	17,363,817.6	-	100%
11	Хөдөлмөр хамгаалал	13,762,000	13,762,000.0	-	100%
12	Тэтгэмж урамшил	9,440,000	9,440,000.0	-	100%
13	Төлбөр хураамж	13,262,476	13,262,476.0	-	100%
14	ТЗБАХЗ	28,608,059	28,608,059.0	-	100%
15	ТУЗ-ийн зардал	5,498,676	4,482,194.0	(1,016,482)	82%
16	<b>Нийт үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>705,894,609</b>	<b>545,655,112</b>	<b>(160,239,497)</b>	<b>77%</b>
17	<b><u>Татварын өмнөх ашиг /алдагдал/</u></b>	<b><u>(156,027,059)</u></b>	<b><u>(16,939,104)</u></b>	<b><u>139,087,955</u></b>	<b><u>11%</u></b>

### ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3.3 сая төгрөг байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангаарх орлогыг илүү 32.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

**Илрүүлэлт:** Шинэчлэгдэж батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа нь тухайн байгууллагад дулааны

ашиглагддаг шугам, барилга байгууламжийн онцлогийг харгалзан тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5.1.6-ийн заалт зохицох зарчмыг хангахгүй, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НББББ-ын өөрт ашиглагддаг үндсэн хөрөнгийн жагсаалтыг нэмэлт өөрчлөлтөөр оруулах.

## 2. Анхан шатны бүрдэлттэй холбоотой

**Илрүүлэлт:** Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй 3.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

## 3. Татварын тайлагналтай холбоотой

**Илрүүлэлт:** НӨАТ-ын татварын тайланг 32.7 сая төгрөгийн зөрүүтэй илгээсэн нь "НББ-ийн тухай хууль 5.1.4.үнэн зөв байх; НӨАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйл.Албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангаарх орлогыг НӨАТ-ын тайланг үнэн зөв гаргах зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, ААНОАТ болон санхүүгийн тайлан зөвөөр тооцож оруулаагүй	1	32,7					1	32,7
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа нь тухайн байгууллагад ашиглагддаг дулааны шугам, барилга байгууламжийг онцлогийг харгалзан тусгаагүй	1						1	-
Анхан шатны бүрдэлттэй холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	3.3					1	3.3
дүн	<b>3</b>	<b>36.1</b>					<b>3</b>	<b>36.1</b>

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>				<b>1</b>			